

КОМПЛАЙНСЫН ГАРЫН АВЛАГА





Энэхүү гарын авлагыг банкнаас бусад санхүүгийн байгууллагад зориулан боловсруулав.

ҮНЭГҮЙ ТАРААГДАНА



КОМПЛАЙНС ГЭЖ ЮУ ВЭ?

Комплајнс нь компанийн засаглалын хяналтын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын зүгээс бодлого, төлөвлөгөө, дагаж мөрдөх стандарт, аргачлал болон хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангах хяналтын тогтолцоо юм.

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫГ ДАРААХ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛНЭ:



Хууль тогтоомж,
дүрэм, журам



Дотоод дүрэм,
журам, аргачлал



Олон улсын
стандарт



Ёс зүйн хэм
хэмжээ



Компанийн
засаглалын
тогтолцоо



Эрсдэлийн
үнэлгээ, удирдлага

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫН АЧ ХОЛБОГДОЛ

Банкнаас бусад санхүүгийн байгууллагын хувьд комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх нь тухайн байгууллагын ажилтан, харилцагч болон дотоод, гадаад хөрөнгө оруулагчдын итгэл үнэмшлийг бэхжүүлэх, өөрийн байгууллагад учирч болохуйц аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Тухайлбал:


Үйл ажиллагааны
үр ашигт байдлыг
нэмэгдүүлэх

Хууль тогтоомжийн хүрээнд
үйл ажиллагаагаа явуулах
нөхцөлийг бүрдүүлэх

Алдаа дутагдал
гарах нөхцөл
боломжийг багасгах

Бизнесийн
давуу тал
болгох

Нэр хүндээ
хамгаалах



Харилцан
итгэлцлийг
бий болгох

Хөрөнгө
оруулалт
татах

Бодит
эрсдэлийг
бууруулах

КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Комплайнсын эрсдэл нь хууль тогтоомж, дүрэм журам, ёс зүйн хэм хэмжээ болон байгууллагын дотоод бодлого зэрэг зөрчигдсөнөөс үүсэх ба дор дурдсанчлан байгууллагын үйл ажиллагааг доголдуулсан хүндрэл, бэрхшээлийг үүсгэдэг:

- 1 Санхүүгийн хууль бус үйлдэл, албан тушаалаа урвуулан ашиглах үйлдэл гарах
- 2 Зохицуулалтын байгууллагаас тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох
- 3 Бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зах зээлд нэвтрүүлэхэд хүндрэл үүсэх
- 4 Байгууллагын болон бизнесийн нэр хүндээ алдах
- 5 Захиргааны арга хэмжээ, торгууль тавигдах
- 6 Албан хаагчдын мэргэжлийн бус үйлдэл гарах.

Эдгээр эрсдэлээс үүдэн байгууллагад дараах хохирлууд учирч болзошгүй. Үүнд:

- материаллаг;
- цаг хугацааны;
- оюуны өмчийн;
- мэдээллийн;
- хөдөлмөрийн хүчний;
- бусад хохирол /хүний амь нас, эрүүл мэнд, байгаль, экологийн гэх мэт/.



КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ БАРИМТЛАХ ҮНДСЭН ЗАРЧМУУД



1

Хараат бус байдал:

- комплайнсын хяналтын үйл ажиллагаа албан ёсны бие даасан байх;
- комплайнсын мэргэжилтэнтэй байх;
- компанийн ажилтнуудын хооронд сонирхлын зөрчил үүсэхгүй байх;
- комплайнсыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөвтэй байх;
- бүх нэгжүүдээс мэдээлэл авах эрх нээлттэй байх.



2

Эрх зүйн байдал: Комплайнсын хяналтыг зохицуулж буй норматив, стандартуудыг байгууллагын дотоод дүрэм, журамд тусгах ба дараах нөхцөлүүдийг багтаасан байна.

- комплайнсын хяналтын зорилго, чиг үүрэг ба комплайнсын ажилтны үүрэг хариуцлага;
- комплайнсын нэгж/ажилтан нь бусад нэгжүүд болон дотоод хяналтын нэгжтэй хамтран ажиллах аргачлал;
- комплайнсын норматив, стандартыг зөрчсөнтэй холбоотойгоор дотоод шалгалт хэрэгжүүлэх эрх;
- комплайнсын чиглэлээр компанийн эрх бүхий этгээдийн тайлагналд хяналт тавих эрх;
- ТУЗ болон түүний хороодтой шууд харьцах эрх.

3

Комплайнсын мэргэжилтний тайлагнал: Компанийн салбар, нэгжид хамаарах комплайнсын мэргэжилтэн өөрийн шууд удирдлагадаа үйл ажиллагаагаа тайлагнахаас гадна комплайнсын чиглэлээр компанийн комплайнсын хяналтын ажилтанд мөн тайлагнана.

4

Сонирхлын зөрчил: Комплайнсын мэргэжилтний хараат бус байдал нь түүний байгууллагад ажиллаж буй ердийн албан тушаалаар хүлээсэн үүрэг, хариуцлагатай сонирхлын зөрчил үүсгэснээр алдагдах магадлалтай учир комплайнсын ажилтан нь зөвхөн комплайнсын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх нь зохистой.

5

Дотоод мэдээллийн нээлттэй байдал:

Комплайнсын нэгж/ажилтан нь өөрийн санаачлагын дагуу байгууллагын бүх нэгжийн албан хаагчидтай хамтран ажиллаж, комплайнсын чиглэлээр дурын мэдээллийг авах эрхтэй.

6

Нөөц: Комплайнсын хяналтын үйл ажиллагааны чухал хэсэг бол мэргэшсэн, туршлагатай хүний нөөц юм. Мэргэжилтнүүд нь байгууллагын зүгээс хууль тогтоомж, эрх зүйн акт, нормативыг мөрдөх, тэдгээрийн үр нөлөө, ач холбогдлын талаар мэргэжлийн түвшний мэдлэгтэй байх шаардлагатай.

7

Зохицуулагч болон хяналтын байгууллагатай хамтран ажиллах: Комплайнсын хяналтын ажилтнууд хяналтын байгууллагатай харилцан үр дүнтэйгээр ажиллах нь маш чухал.

- хяналтын байгууллагаас шаардсан баримт, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж, хүргүүлэх;
- маргаантай асуудлаар хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах гэх мэт.

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫН ОНЦЛОГ БА ЯЛГАА

Комплайнсын хяналтын чиг үүргүүдийг харахад санхүүгийн байгууллагуудын дотоод аудит болон дотоод хяналтын чиг үүрэгтэй ижил байдал ажиглагддаг бөгөөд “Базелийн хороо”-ноос комплайнсын хяналт болон дотоод аудит, дотоод хяналтын чиг үүргүүдийг тусгаарлах, комплайнсын хяналтын үйл ажиллагааг тодорхой цаг хугацааны үечилсэн байдлаар үнэлж байхыг зөвлөсөн.

Хараат бус бие даасан үнэлгээ хийх (дотоод аудит) болон комплайнсын эрсдэлийг тогтоох, удирдах аргачлалыг нэгэн зэрэг хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд чиг үүрэг, зорилтуудын хувьд ч өөр өөр байдаг тул байгууллага дотоод аудит, дотоод хяналт болон комплайнсыг хэрэгжүүлэх мэргэжилтнүүдийн чиг үүргийг нарийвчлан тодорхойлж өгөх нь зүйтэй.

ДОТООД ХЯНАЛТ


Байгууллагын зорилтыг биелүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд тусгагдан, байгууллагын бүх ажилтнууд мөрдөн, биелүүлэх цогц арга хэмжээ

КОМПЛАЙНС

Бодлого, төлөвлөгөө, дагаж мөрдөх стандарт, аргачлал болон хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах тухайн байгууллагын хяналтын тогтолцоо

ДОТООД АУДИТ

Дотоод аудит нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой, баталгаа өгөх, зөвлөх үйл ажиллагаа /Энэ нь системтэй, оновчтой арга хандлагаар байгууллагын эрсдэлийн удирдлага, засаглал ба дотоод хяналтын үйл явцыг үнэлэх ба сайжруулахад тусалдаг/



Дотоод хяналт, комплайнс болон дотоод аудитыг хэрэгжүүлэх байдал нь цаг хугацааны хувьд ихээхэн ялгаатай.

КОМПЛАЙНС

Эрсдэлийг удирдах үүрэг бүхий комплайнсын хяналт нь байгууллагын бүх шатанд үүсэж болзошгүй комплайнсын эрсдэлийг тооцон уялдуулснаар цаг хугацааны хувьд урьдчилсан төлөвт ажилладаг.



ДОТООД ХЯНАЛТ

Удирдлага болон ажилтан өөрийн хариуцсан чиг үүргээ гүйцэтгэж байх одоо цагийн үйл явцад хяналт тавьдаг.

ДОТООД АУДИТ

Олон улсын стандартад зааснаар дотоод аудитыг аль болох эрсдэлд суурилсан байдлаар хийх шаардлагыг тавьж байгаа хэдий ч практикт ихэвчлэн алдаа дутагдал, зөрчил гарсны дараагаар аудит хийгдэж, дотоод хяналтын аль процесст алдаа гарсныг илрүүлж, залруулах талаар зөвлөмж хүргүүлдэг.

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫГ ХЭРХЭН ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ВЭ?

Байгууллагадаа комплайнсын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд комплайнсын нэгж/ажилтан нь холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг судалж, байгууллагынхаа хэмжээнд хэрэгжүүлэх комплайнсын хөтөлбөр боловсруулах хэрэгтэй.

Ингэснээр байгууллагын комплайнсын үйл ажиллагаа албажин баталгаажих бөгөөд хууль тогтоомж, дүрэм журам, стандартуудыг дагаж мөрдөхөд чиглэсэн байгууллагын дотоод бодлого, журмыг багцалж, илүү тодорхой, ойлгомжтой болох нөхцөл бүрддэг.

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫН СИСТЕМИЙГ 3 ТҮВШИНД АНГИЛДАГ

1 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ



- комплайнсын эрсдэлийг үнэлэх, илрүүлэх;
- бодлого, дүрэм, журам, аргачлал боловсруулах;
- комплайнсын ажилтан томилох;
- сургалт явуулах.

2 ИЛРҮҮЛЭХ



- мэдээлэл солилцох, тайлагнах суваг;
- хяналт/аудитын тайлан;
- МУТСТ.

3 ЗАЛРУУЛГА



- алдаанд дүгнэлт гаргах;
- залруулах, эрх зүйн сайжруулалт хийх;
- мэдээллийг ил тод тайлагнах, сурталчлан таниулах.

КОМПЛАЙНСЫН ХӨТӨЛБӨРТ БАГТААХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ДҮРЭМ, ЖУРАМ, АРГАЧЛАЛ

✓ Ёс зүйн хэм хэмжээ

ажилтнуудын ёс зүй, биеэ авч явах хэм хэмжээ болон үүрэг, хариуцлагыг тодорхойлж, үндсэн зарчмуудыг тусгах;

✓ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

хууль бус орлогыг санхүүгийн салбарт оруулан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, дотоод журам боловсруулах;

✓ Бэлэг хүлээн авах, бэлэглэх

бэлэг, авлига, албан тушаалаа урвуулан ашиглаж ашиг олох зэргийг нарийвчлан тогтоох / Тухайлбал бэлэг авах үйлдэлд бүхэлд нь хориг тавих бус, түүний үнэ өртөгт хязгаар тавих, бэлэглэх, бэлэг хүлээн авах үйл явцыг дотоод журмаар зохицуулах/;

✓ Ёс зүйн хэм хэмжээ зөрчсөнийг мэдээлэх

ажилтнуудын гаргасан ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэл авах, баримтжуулах, мэдээлэгчийн нууцлалыг хадгалах;

✓ Сонирхлын зөрчлийг зохицуулах

сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд байгууллагын ажилтнуудын авч хэрэгжүүлэх ёс зүйн арга хэмжээний аргачлал боловсруулах;

✓ Ажилтан үнэт цаас худалдан авах

санхүүгийн байгууллагын ажилтнууд үнэт цаасны зах зээлд оролцох үед баримтлан хэрэгжүүлэх хэм хэмжээг тогтоох;

✓ Мэдээллийн тусгаарлалт /цагаан хэрэм/

мэдээллийн хана буюу дотоод мэдээллийн нууцлал хадгалалтын байдлыг сайжруулах;

✓ Ёс зүйн хэм хэмжээ

харилцагч болон түүний хэлцлийн талаарх мэдээллийг нууцлах хяналтыг бий болгох.

Комплайынсын хяналтын талаар дараах стандарт, ном, сэтгүүл болон цахим хуудаснаас мэдээлэл авах боломжтой.



frc.mn/4/s/25

SAKHUUGIIN ZOXIICUULAH ХОРДО

БИДИЙН ТУХАЙ ЗОХИЦУУЛАГЧИН САЛГААРУД МОНГО УГААХТАЙ ТӨМӨДХ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ШИЛЭН ДАНС ИЛ ТӨД БАЙДАЛ ТАНЫ УГСХАА ХЯНАЛТ ШАГАЛТ ХӨРӨГӨ БАРИХ

Хайлт хийх...

Эхлэл > Компанийн засаглал, комплайнс

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПАЙНС

БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН КОМПАЙНСЫН АЖИЛТНУДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

КЭХИЙН ТАНИЛЦУУЛАГ, ЧИГ ҮҮРЭГ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМУУД(ЗӨХАХС)

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ


НИЙТЛЭЛЭЛ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХӨРӨГЧИН ДҮРЭМ

ҮЛГЭРЧИЛСЭН ЖУРМУУД

Компанийн засаглал, комплайнс

№	НӨР	ҮЗЭХ
	Хайлт хийх...	
1	Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийг хурлын зар хүргэх журам	Үзэх
2	Саяаг хураах кумулятив аргыг хэрэглэх журмын төсөлд саяаг авах нь	Үзэх
3	Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын комплаенсын ажилтнуудад зориулсан гарын авлага	Үзэх
4	Компанийн засаглалын зарчмуудын товч танилцуулаг	Үзэх
5	Комплайынсын тухай	Үзэх
6	Хэлтсийн танилцуулаг чиг үүрэг	Үзэх
7	"Унхт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хураах тухай журам" батлах тухай	Үзэх
8	Монголын компанийн засаглалын кодекс	Үзэх
9	Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм	Үзэх



www.frc.mn

www.facebook.com/FRC.of.Mongolia

51-264444

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

webmaster@frc.mn